



ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/411

Зуунмод

Төслийн зээл олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2, 59.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А/361 дүгээр тушаал, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 03, 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 11 тоот тогтоол, Хоршоо хөгжүүлэх сангийн зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 05 тоот хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хоршоо хөгжүүлэх сан”-гийн зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 05 дугаар хуралдаанаар хэлэлцэн шалгарсан хоршоо, аж ахуйн нэгж, иргэдийн төслүүдийг хавсралтаар баталсугай.


2.Зээл авахаар зөвшөөрөгдсөн хоршоо, аж ахуйн нэгж, иргэдийн зээлийг олгож, эргэн төлөлтөнд хяналт тавьж ажиллахыг “Хоршоо хөгжүүлэх сан”-гийн Нарийн бичгийн дарга (Б.Батжаргал), Нягтлан бодогч (М.Номин-Эрдэнэ) нарт даалгасугай.

3.Хоршоо, аж ахуй нэгж, иргэд зээлээ зориулалтын дагуу ашиглан, шинээр бий болгох ажлын байр, нийгмийн даатгал төлсөн байдал зэргийг баталгаажуулж, эргэн төлөлтөө хуваарийн дагуу хийж ажиллахыг төсөл хэрэгжүүлэгч нарт үүрэг болгосугай.

4.Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан хоршоо, аж ахуй нэгж, иргэдийн зээлийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг “Хоршоо хөгжүүлэх сан”-гийн Төсөл сонгон шалгаруулах зөвлөл, Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдэд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.САРАНГЭРЭЛ



Сумын Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 1741 дугаар захирамжийн хавсралт.

ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ЗЭЭЛ АВАХ ХОРШОО,
АЖ АХУЙ НЭГЖ, ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

№	Төсөл хэрэгжүүлэгч хоршоо, аж ахуй нэгж, иргэний нэр	Төсөл хэрэгжүүлэгч хоршоо, аж ахуй нэгжийн захирлын нэр	Төслийн нэр	Багийн харьяа	Мөнгөн дүн /сая.төг/
1	2	3	4	5	6
1	Т.Наранбаатар		“Calm green” мод үржүүлэг	1-р баг	10.0
2	Б.Батсайхан		“Урлахуйн хүч” мод модон эдлэл	1-р баг	10.0
3	“Манзуширын сүрэг” ХХК	С.Өлзийдэлгэр	“Эко хүнс” боловсруулах төсөл	6-р баг	10.0
4	“Төгс тариа” ХХК	Б.Болдбаяр	Талх нарийн боовны цех өргөтгөх төсөл	1-р баг	7.0
5	Г.Нансалмаа		“Гурван баян” төсөл	3-р баг	10.0
6	Ц.Цогнийжав		Шуурхай түгээх цэгийн бетон эдлэл үйлдвэрлэлийн төсөл	5-р баг	40.0
	Дүн				87.0

ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САН.